



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний
хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, 7.1.13 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарт:

1.1 Монгол улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн “7.2. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга нар хариуцан зохион байгуулна” гэсэн заалтын дагуу уг хөтөлбөрийн хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг орон нутагт зохион байгуулах;

1.2 Эрүүл мэндийн сайдын 2019 оны 163, 116, А/537 дугаар тушаалын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллах;

1.3 Эрүүл мэндийн сайдын 2019 оны 116 дугаар тушаалын дагуу аймгийн Эрүүл мэндийн газар нь орон нутагтаа амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээг зохион байгуулах баг байгуулан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмчид зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

1.4 Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар “Заавар батлах тухай” шинэчилсэн тушаалын 5 дугаар хавсралтын дагуу халдварын сэргийлэлт, хяналтыг удирдан зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч ажиллах;

1.5 Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөв, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.6 Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэгт шүдний тусламж, үйлчилгээ авсан хүүхдийн мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мэдээлэлтэй нэгтгэн тайлагнах;

143200003

1.7 “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, түүний ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах зорилготой “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнийг зохион байгуулсан нь хүүхдэд шүд угаах зөв дадал төлөвшүүлэх чухал ач холбогдолтой шилдэг туршлагыг судлан өөрийн орон нутагтаа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг үүрэг болгож байна.

Хоёр. Нүүр, ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Монголын шүдний эмч нарын холбоонд даалгах нь:

2.1 Шүдний эмнэлэг болон энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагууд, эмч, мэргэжилтнүүд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 163, 116, А/537 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллах;

2.2 Шүдний тусламж, үйлчилгээг алслагдсан сум, багт хүргэх явуулын тусламж, үйлчилгээ үзүүлэх зааврыг боловсруулж, батлуулах;

2.3 Эрүүл мэндийн сайдын 116 дугаар тушаалын дагуу аймаг, нийслэлд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээг зохион байгуулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангах;


2.4 Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар “Заавар батлах тухай” шинэчилсэн тушаалын халдварын сэргийлэлт, хяналтын талаар шүдний эмнэлгийн эмч, мэргэжилтэнд сургалт зохион байгуулах шаардлагатай байгааг анхаарч, идэвхтэй хамтран ажиллах.

Гурав. Халдварт өвчин судлалын үндэсний төвд даалгах нь:

3.1 Шүдний эмнэлэг болон энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бүх түвшний эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар “Заавар батлах тухай” шинэчилсэн тушаалын 5 дугаар хавсралтын дагуу халдварын сэргийлэлт, хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;

Дөрөв. Уг албан даалгаврын хэрэгжилтийг гарган, энэ оны 6 дугаар сарын 25-ны өдөр болон 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭГИ